



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/285

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс эх орныхоо ирээдүй, хөгжил цэцэглэлтийн эх ундарга залуу үеийг соён гэгээрүүлэх, сурган хүмүүжүүлэх, дээд боловсролын үйлчилгээг чанартай хүргэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, авьяас чадвар, сэтгэл оюунаа дайчлан идэвх, санаачилга, үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ "Орчин цагийн хятад, монгол хэлний хүний бие эрхтний нэрийн харьцуулсан судалгаа" сэдвээр хэл шинжлэлийн ухааны Докторын зэрэг амжилттай хамгаалсан Ховд Их сургууль, Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн гадаад хэл, соёл судлалын тэнхимийн ахлах багш Баасандоржийн Ариунболорыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Б.Ариунболорт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Ховд их сургуулийн захирал /Б.Нямдорж/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 01407
D/Zax-N/285-Da